



ОРХОН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2017 оны 06 сарын 13 өдөр

Дугаар A/321


Эрдэнэт

┌ Тамирчинд дэмжлэг үзүүлэх тухай ─┐

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5/a/, 29.2, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2016 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн ээлжит IV хуралдааны 2 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.2017 оны 06 дугаар сарын 26-наас 07 дугаар сарын 03-ны өдрүүдэд БНХАУ-ын Ханжоу хотод зохион байгуулагдах суугаа волейболын Ази, Номхон далайн орнуудын аварга шалгаруулах тэмцээнд Орхон аймгийг төлөөлж оролцох тамирчин Н.Оюунжаргалд 1000000 төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг тус тус үзүүлсүгэй.

2.Зардалд шаардагдах 1000000 /Нэг сая/ төгрөгийг Засаг даргын нөөц сан хуваарилагдаагүй бусад зардлын "Соёл, спорт, хүүхэд залуучууд, олон нийтийн арга хэмжээг жилийн туршид зохион байгуулах арга хэмжээний зардал"-аас гаргахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс /н.Бямбацэцэг/-т зөвшөөрсүгэй.


 ЗАСАГ ДАРГА Д.БАТЛУТ